

Өмнөх үг

Уншигч авхай танд толилуулж буй МУИС-ийн геологийн салбараас эрхлэн гаргаж буй энэхүү сэтгүүлд эрдэм шинжилгээний гутгаар ба дөтгөөр цувралуудыг нэгтгэсэн болно.

Энэхүү бүтээлд Монголын геологичидийн сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны ажлын үр дүн, явцыг тусгахыг оролдлоо. Эдгээр бүтээлүүд нь дотроо *Геотектоник, Стратиграф ба палеонтолог, Седиментолог, Магматизм, Газарзүй ба геоморфолог, Гидрогеолог ба инженер геолог, Ашигт малтмал* гэсэн ерөнхий бүлгүүдээс бүрдэх бөгөөд эцэст нь мэдээлэлийн чанартай материалыг нийтэлсэн болно.

"Геотектоник" хэмээх бүлэгт Ж.Бямба, О.Төмөртогоо, Г.Бадарч, Ц.Махбадар, А.Баясгалан, Д.Жанчив нарын бичсэн Монголын нутаг дэвсгэрт эх газрын царцдас бүрэлдсэн үе шатууд ба түүний үүсэхэд офиолит эвшлийн үүрэг болон Монголын тектоникийн хөгжлийн явцад хийсэн террейний шинжилгээний үр дүн, Умард Монголын хожуу палеозой-мезозойн рифтогенез хийгээд Монголын идэвхитэй хагарал, Өмнөд Монголын мезозойн хотгоруудын тектоникийн хөгжлийг гарал үүсэл, шалтгааны холбоотой тайлбарласан болно.

Уг эмхэтгэлийн хамгийн их хэмжээтэй бүлэг бол стратиграф ба палеонтологийн хэсэг юм. Энд Ж.Бямба, А.Амаржаргал нарын бичсэн кембрийн өмнөх үеийн стратиграфын материалаас аваад Д.Дашзэвэгийн бичсэн палеоцен ба эоцений заагийн тив хоорондын харьцуулалтыг хүртэл өргөн хүрээтэй мэдээлэл багтсан байна. Ялангуяа Я.Бат-Ирээдүй, А.С.Гибшер нар Завханы структур-фаацын бүсийн хэмжээнд кембри, кембрийн өмнөх үеийн хил заагийг тогтоохыг оролдсон, сүүлийн үед ордовик, силүрийн стратиграфын талаар хуримталсан нүсэр их мэдээлэлийг боловсруулсан Ч.Минжингийн, Я.Ариунчимэгийн Монголын палеозойн хөвд биетэнээр хийсэн палеонтологийн нэгтгэл материал зэрэг нь өргөн уудам нутгийг хамарсан чухал ая холбогдолтой болжээ. Түүнээс гадна Монголын юрийн геологийн талаар (Ж.Бадамгарав), доод цэрдийн хурдасны стратиграфын тухай (А.Амаржаргал), тодорхой дүүргүүдийн стратиграфын ба палеонтологийн асуудлуудыг хөндсөн өгүүлэлүүд (А.Бойшпенко, Ц.Махбадар, Я.Ариунчимэг, К.Сабат) сонирхолтой болжээ.

Ж.Бямбын Заг-Хараагийн бүсийн лавиний хурдас хуримтлал (Төв Монгол), С.Ариунбилэг, П.Хосбаяр, Ц.Наранцэцэг нарын Хөвсгөл нуурын ёроолын тундасны судалгаа зэрэг материалууд "Седиментологи" хэмээх бүлэгт багтжээ.

Магматизмын хэсэгт Ж.Бямба, О.Гэрэл, А.Амаржаргал нарын боржинлог чулуулгийн петрогеохимийн үндсэн дээр геодинамикийн байдлыг сэргээхийг оролдсон ажлууд, Д.Оролмаагийн Хангайн түрүү мезозойн вулканизмын тухай ба Ж.Лхамсүрэнгийн Монгол орны флюорит дахь эрдэс төрүүлэгч уусмалын ормын судалгааны томоохон нэгтгэл нь гарал үүслийн чухал асуудлуудыг хөнджээ. Монголын шавар довцогийн тухай мэдээлэлийг П.Хосбаяр, С.Ариунбилэг нар хийсэн нь тус орны хувьд анхных нь юм.

Уг эмхэтгэлд томоохон байр суурийг "Газарзүй ба геоморфологи" хэмээх бүлэгт багтсан мэдээлэлүүд эзлэнэ. Энд Ж.Бямбын Монголын газарзүйн дүүрэгчилэлийн асуудлыг хөндсөн томоохон өгүүлэлээс гадна П.Хосбаяр, Ч.Алтанзул, Я.Болд, Х.Уламбадрах, М.Мягмаржав, Ч.Ганзүрх нарын тодорхой дүүргүүдийн геоморфологи, морфоструктүүрийн ба морфометрийн судалгааны дүнгүүдээс тусгасан мэдээлэлүүд хэвлэгдсэн.

Нутаг дэвсгэр нь эрс тэс хуурай уур амьсгалтай Монгол орны хувьд гидрогеологийн ба инженер геологийн талаар туурвисан Н.Жадамбаа,

Г.Удвалцэцэг, Г.Цэрэнжав нарын бүс нутгийг хамарсан материал нөөцийн тооцоо, тархалтыг тусгаснаараа үнэтэй юм. Монгол орны усан хангамжаар муу байгаа зарим нутгийн гидрогеологийн нөхцөлийн тухай ба түүнийг шийдвэрлэх арга замын тухай мэдээлэл Р.Баттөмөрийн өгүүлэлүүдэд тусгалаа олжээ. Сүүлийн үед судалгааны чиглэлээс гадуур байгаа рашааны тухай материал З.Нарангэрэлийн мэдээлэлд тусгагдсан нь сайшаалтай.

Орон даяар сүүлийн үед өрнөж байгаа байгалийн хийн ба авто замын чиглэлийн нэгэн хэсгийн дагуу М.Мягмаржав, Ч.Ганзүрх, Я.Болд нарын хийсэн инженер геологийн судалгаа сонирхсон хүмүүсийн анхаарлыг татна гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэхүү эмхэтгэлийн сүүлийн бүлэгт Монгол Алтайн металлогени (С.Дандар, Г.Дэжидмаа), Монголын шороон ордуудын гарал үүслийн төрлүүд (Я.Болд), Дорнод Монголын цайр-хартугалганы хүдэржилтийн байршилт (Д.Доржготов, Ш.Батжаргал), Монголын шатах ашигт малтмал (Д.Бат-Эрдэнэ) талаар томоохон бүтээлүүд орсон нь чухал ач холбогдолтой болжээ. Мөн Д.Доржнамжаа, С.Энхтайван нарын ба Д.Шархүүхэний алтны ба цагаан алтны орд, илрэлүүд нээгдсэн тухай сонирхолтой шинэлэг мэдээлүүд багтсан болно.

Нийтэд нь дүгнэж үзвэл энэхүү эмхэтгэлд орсон манай эрдэмтэн геологичидийн бүтээлүүд нь Монголын геологийн судалгааны шинжлэх ухааны түвшин, чанарыг дээшлүүлэхээс гадна улс ардын аж ахуйд чухал ач холбогдолтой ашигт малтмалын ордуудын зүй тогтолыг танин мэдэж улмаар нээж илрүүлэхэд бага ч болов нэмэр хандив болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Редакцийн зөвлөл